



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор сумын ИТХ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/70/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2020 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: М.Алтантуяа Утас:99061861 Цахим хаяг:.....</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.13. Шилэн дансны мэдээлэл	8
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж өгөгдөгүй болно.....	8
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	10
3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	10
3.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	11
3.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	12
3.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	13
3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	14



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2020.02.27 № 1/299

танай _____ -ны № _____ -т

Г _____ Г

Аудитын гэрчилгээ

Г БАЯНХОНГОР СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Ж.БЯМБАСҮРЭН ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\ 005020260

болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

2.1. Оршил

Баянхонгор сумын ИТХ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Баянхонгор сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Ж.Бямбасүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.23-наас 2020.02.25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор М.Алтантуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор сумын ИТХ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020.01.07-ны өдрийн 16/03 тоот бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Эрхэм зорилго: “Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хүний хөгжилд тулгуурласан, төр иргэний хамтын ажиллагаанд суурилсан, нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр сумын нийгэм, эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангасан нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг бэхжүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

Баянхонгор сумын ИТХ-ын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баянхонгор сумын ИТХ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор сумын ИТХ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acoulas” программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор сумын ИТХ нь төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 31 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 31 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр БСУГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "их" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 108266,5 мянган төгрөгөөс тооцон 2165,3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 3028,8 мянган төгрөгөөр тооцсон.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор сумын ИТХ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6962,5 мянган төгрөгөөр буюу 27,9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	-
Авлага	-	560.4	560.4
Урьдчилгаа	-	-	
Бараа материал	4,023.7	5,674.6	1,650.9
Үндсэн хөрөнгө	63,997.2	63,997.2	-
Хуримтлагдсан элэгдэл	(43,106.0)	(52,292.3)	(9,186.3)
Нийт хөрөнгө	24,914.9	17,939.9	(6,975.0)
Өр төлбөр	12.5	-	(12.5)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	24902,4	17,939.9	(6,962.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	24914,9	17,939.9	(6,962.5)

Бараа материалын данс 1650,9 мянган төгрөгөөр өссөн нь төгрөгийн барилгын засварын материал 600.0 мянга, бичиг хэргийн материал 104,5 мянга, бусад материал 946.0 мянган төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгөнд хөдөлгөөн ороогүй, өглөг 12,5 мянган төгрөгийг барагдуулсан, Засгийн газрын оролцоо данс тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөр 6962,5 мянган төгрөгөөр буурсан байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант жилд 143418,0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 43387,9 мянган төгрөг зарцуулж 27,8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан өвлөрүүлсэн. Батлагдсан орон тоо 23 / үндсэн орон тоо 5, БИНХ дарга 9, Гэрээт олон нийт хариуцсан цагдаа 9/ байхаас 25 орон тойгоор ажилласан нь Баянхонгор сум 1-р багийг 2 салган 10-р баг шинээр бий болсонтой холбогдуулан БИНХ дарга-1, олон нийт хариуцсан цагдаа 1 нийт 2 орон тоо нэмэгдсэн.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 30 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 29 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж үзлээ.

Аудитаар дараах 560,4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснийг санхүүгийн тайланд залруулав. Үүнд:

1. Цалин, НДШ-ийн өглөгийг цалингийн хүснэгт, журналын бичилттэй тулгахад 560,4 мянган төгрөгийн Нийгмийн даатгалд илүү шилжүүлж санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-т "үнэн зөв байх", 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг бүртгэнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулав.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор сумын ИТХ-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 127 мэдээллийг хугацаанд нь, 22 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Баянхонгор сумын ИТХ нь 2019 оны 6, 9, 10 дугар саруудад тухай бүрт оруулах 7 мэдээ, сар бүр оруулах 2 мэдээ, улирал бүр оруулах 1 мэдээ, бүтэн жилээр оруулах 1 мэдээ нийт 11 мэдээлэлд засвар хийгдсэн.

2019 оны 8 сарын тухай бүр оруулах 8 мэдээ, сар бүр оруулах 3 мэдээг ээлжийн амралттай байсаны уламаас 11 мэдээг хугацаа хоцроож мэдээллсэн.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	8	11	8	1	2
2	Хагас жил	1	4	4	-	-
3	Улирал бүр	1	4	3	1	-
4	Сар бүр	3	36	31	5	-
	Тухай бүр	8	96	81	15	-
	Нийт	21	151	127	22	2

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж өгөгдөөгүй болно.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор сумын ИТХ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Бид Баянхонгор сумын ИТХ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,023,693.00	6,235,004.82
33	АВЛАГА	00.00	560,411.82
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	560,411.82
35	БАРАА МАТЕРИАЛ	4,023,693.00	5,674,593.00
354	Хангамжийн материал	4,023,693.00	5,674,593.00
35410	Бичиг хэргийн материал	109,000.00	213,500.00
35420	Аж ахуйн материал	1,090,250.00	1,129,250.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,920,000.00	1,920,000.00
35440	Түлш, шатах тослох материал	32,600.00	00.00
35450	Барилгын засварын материал	220,010.00	820,010.00
35470	Бусад хангамжийн материал	651,833.00	1,591,833.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	20,891,229.56	11,704,930.55
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	20,891,229.56	11,704,930.55
392	Биет хөрөнгө	20,688,729.68	11,539,930.67
39203	Авто-тээврийн хэрэгсэл	47,492,000.00	47,492,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-31,320,944.39	-39,236,277.71
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	9,925,900.00	9,925,900.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-6,417,733.08	-7,438,566.62
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,064,340.00	6,064,340.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,194,832.85	-5,407,465.00
39217	Ном	140,000.00	140,000.00
393	Биет бус хөрөнгө	202,499.88	164,999.88
39301	Програм хангамж	375,000.00	375,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-172,500.12	-210,000.12
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	24,914,922.56	17,939,935.37
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	12,525.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	12,525.00	00.00
413	Өглөг	12,525.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	12,525.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	24,902,397.56	17,939,935.37
51	Засгийн газрын хувь оролцоо	24,902,397.56	17,939,935.37
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	21,281,230.42	21,281,230.42
51101	Өмч: - төрийн	21,281,230.42	21,281,230.42
512	Хуримтлагдсан үр дүн	1,534,141.30	-5,428,320.89
51210	Өмнөх үеийн үр дүн	1,534,141.30	1,534,141.30
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-6,962,462.19
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,087,025.84	2,087,025.84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	24,914,922.56	17,939,935.37

3.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	124,260,118.00	143,915,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	124,260,118.00	143,915,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	500,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	119,888,100.00	143,415,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	119,888,100.00	143,415,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,372,018.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3,372,018.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	129,972,474.89	150,878,262.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	129,972,474.89	150,878,262.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	125,694,324.89	150,850,453.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	84,048,855.00	101,945,184.61
210101	Үндсэн цалин	67,184,655.00	82,583,333.61
210104	Урамшуулал	16,864,200.00	19,361,851.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,894,470.00	12,801,368.84
210201	Тэтгэврийн даатгал	8,660,976.00	8,754,268.84
210202	Тэтгэмжийн даатгал	246,699.00	1,011,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	308,374.00	809,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	61,672.00	202,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	616,749.00	2,023,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,964,748.00	7,289,261.00
210401	Бичиг хэрэг	3,270,300.00	3,315,050.00
210402	Тээвэр, шатахуун	2,105,900.00	3,404,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	588,548.00	569,611.00
2105	Нормативт зардал	1,200,000.00	2,402,600.00
210502	Хоол, хүнс	1,200,000.00	2,402,600.00
2107	Томилолт, зочны зардал	1,243,000.00	1,844,200.00
210702	Дотоод албан томилолт	1,243,000.00	1,844,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хурдаамж	1,848,420.00	736,040.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хурдаамж	1,848,420.00	736,040.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,494,831.89	23,831,799.01
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,295,000.00	11,655,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	2,990,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9,199,831.89	9,186,299.01
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,278,150.00	27,808.73
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,372,018.00	00.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	3,372,018.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох гатаас, санхүүжилт	906,132.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	906,132.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	27,808.73
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	27,808.73
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-5,712,356.89	-6,962,462.19
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-5,712,356.89	-6,962,462.19

3.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	124,260,118.00	143,915,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	124,260,118.00	143,915,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	500,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	119,888,100.00	143,415,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	119,888,100.00	143,415,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,372,018.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3,372,018.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	124,260,118.00	143,915,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	124,260,118.00	143,915,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	119,981,968.00	143,887,991.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	84,048,855.00	102,506,190.27
210101	Үндсэн цалин	67,262,730.00	83,412,170.27
210104	Урамшуулал	16,786,125.00	19,094,020.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,881,945.00	12,813,300.00
210201	Тэтгэврийн даатгал	8,648,448.00	8,766,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	246,699.00	1,011,800.00
210203	ҮОМШО-ний даатгал	308,374.00	809,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	61,672.00	202,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	616,752.00	2,023,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,964,748.00	7,020,161.00
210401	Бичиг хэрэг	3,365,300.00	2,779,550.00
210402	Тээвэр, шатахуун	2,010,900.00	3,632,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	588,548.00	608,611.00
2105	Нормативт зардал	1,200,000.00	2,667,600.00
210502	Хоол, хүнс	1,200,000.00	2,667,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,500,000.00	00.00
210602	Тавилга	1,800,000.00	00.00
210604	Урсгал засвар	1,700,000.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	1,243,000.00	1,844,200.00
210702	Догоод албан томилолт	1,243,000.00	1,844,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,848,420.00	1,236,040.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,848,420.00	1,236,040.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,295,000.00	15,800,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,295,000.00	12,803,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	2,996,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,278,150.00	27,808.73
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,372,018.00	00.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	3,372,018.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	906,132.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	906,132.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	27,808.73
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	27,808.73
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

3.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	21,281,230.42	2,087,025.84	8,946,498.19	32,314,754.45
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	21,281,230.42	2,087,025.84	8,946,498.19	32,314,754.45
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-5,712,356.89	-5,712,356.89
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	21,281,230.42	2,087,025.84	1,534,141.30	24,902,397.56
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	21,281,230.42	2,087,025.84	1,534,141.30	24,902,397.56
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	21,281,230.42	2,087,025.84	1,534,141.30	24,902,397.56
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-6,962,462.19	-6,962,462.19
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	21,281,230.42	2,087,025.84	-5,428,320.89	17,939,935.37

3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	143,415,800.00	143,387,991.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	143,415,800.00	143,387,991.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	143,415,800.00	143,387,991.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	102,507,300.00	102,506,190.27
210101	Үндсэн цалин	83,242,300.00	83,412,170.27
210104	Урамшуулал	19,265,000.00	19,094,020.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх ц	12,813,300.00	12,813,300.00
210201	Тэтгэврийн даатгал	8,766,200.00	8,766,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,011,800.00	1,011,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	809,400.00	809,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	202,400.00	202,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,023,500.00	2,023,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,027,400.00	7,020,161.00
210401	Бичиг хэрэг	2,778,200.00	2,779,550.00
210402	Тээвэр, шатахуун	3,632,000.00	3,632,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	617,200.00	608,611.00
2105	Нормативт зардал	2,667,600.00	2,667,600.00
210502	Хоол, хүнс	2,667,600.00	2,667,600.00
2107	Томилолт, зочны зардал	1,844,200.00	1,844,200.00
210702	Дотоод албан томилолт	1,844,200.00	1,844,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний	752,200.00	736,040.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил ү	752,200.00	736,040.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15803800.00	15800500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,803,800.00	12,803,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.00	2,996,700.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	143,415,800.00	143,387,991.27
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	143,415,800.00	143,387,991.27
132001	Орон нутгийн төсвөөс	143,415,800.00	143,387,991.27
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23.00	23.00
620001	Удирдах ажилтан	02.00	02.00
620002	Гүйцэтгэх ажилтан	02.00	02.00
620003	Үйлчлэх ажилтан	19.00	19.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25.00	25.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	02.00	02.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	02.00	02.00
650010	Гэрээт ажилтан	10.00	10.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	11.00	11.00

3.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийг төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг

Дансны код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		500,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		500,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		500,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		500,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

САНХҮҮГИЙН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

ОГНОО: 2020.02.27

ХЯНАСАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ

ОГНОО:2020.02.27

ТАЙЛАН БИЧСЭН АУДИТОР

М.АЛТАНТУЯА

ОГНОО : 2020.02.27